

Баталсан хууль нь хүн
бүрт тэгш үйлчилдэг
тор л халгийн
тогтвортой оршдог.

Аристотель

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН БОЛОН ЯПОН УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХАРЬЯА СУРГАЛТ, СУДАЛГААНЫ ХҮРЭЭЛЭН(RTI)-ИЙН ХАМТАРСАН “ГЭМТ ХЭРГИЙН ЦАГААН НОМЫН ҮР ДҮНГ ЭРҮҮГИЙН БОДЛОГО ТОДОРХОЙЛОХОД АШИГЛАХ НЬ: МОНГОЛ УЛС БА ЯПОН УЛС” СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ СЕМИНАР АМЖИЛТТАЙ БОЛЛОО.

Хууль зүйн үндэсний хүрээлэн болон Япон ажиллагааны хүрээнд 2024 оны 9 дүгээр сарын тодорхойлоход ашиглах нь: Монгол Улс ба Улсын Хууль зүйн яамны харьяа Сургалт, 5-ны өдөр Хуульчдын танхимд “Гэмт хэргийн Япон Улс” сэдвээр эрдэм шинжилгээний судалгааны хүрээлэн(RTI) хоорондын хамтын цагаан номын үр дүнг эрүүгийн бодлого хамтарсан семинар зохион байгууллаа.



Семинарыг нээж Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, хууль зүйн ухааны доктор Х.Эрдэм-Ундрах (Dr.jur), Япон Улсын Хууль зүйн яамны харьяа Сургалт, судалгааны хүрээлэнгийн Олон улсын хамтын ажиллагааны газрын захирал Рёота Татэмото нар үг хэлэв. Сургалт, судалгааны хүрээлэнгийн Олон улсын хамтын ажиллагааны газрын профессор

Кэйсүкэ Гото “Гэмт хэргийн цагаан номын үр дүнг эрүүгийн бодлого тодорхойлоход ашиглах нь: Япон Улс”, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын эрдэм шинжилгээний ажилтан Б.Ариунжаргал “Монгол Улсын төрийн эрүүгийн бодлогыг тодорхойлоход гэмт хэргийн цагаан номын ач холбогдол, цаашдын чиг хандлага”, Монгол

Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах хэлтсийн дарга Б.Одмандха “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны эрх зүйн үндэс, чиг үүрэг” сэдвээр тус тус илтгэл тавьж хэлэлцүүлсэн.

Японы талаас Сургалт, судалгааны хүрээлэнгийн Олон улсын хамтын ажиллагааны газрын ажилтан Рэй Шимажири, МУИС-ийн ХЗС-ийн багш, Кюүшүгийн их сургуулийн докторант С.Батбаяр, Монголын талаас УЕПГ-ын Сургалт, судалгааны хүрээлэнгийн хяналтын прокурор, хууль зүйн ухааны доктор Ц.Мөнхбат, хуульч, хууль зүйн

ухааны доктор, хурандаа Р.Оюунбадам, Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров, Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын судлаач Г.Оюунболд болон Хууль зүйн үндэсний хүрээлэн, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, Дотоод хэргийн их сургууль, Шихихутуг их сургууль

зэрэг байгууллагын эрдэмтэн багш, судлаач, мэргэжилтнүүд уг семинарт оролцож, идэвхтэй хэлэлцүүлэг өрнүүлэв. Семинарын чиглүүлэгчээр ХЗҮХ-ийн Хүний эрх, олон улсын эрх зүйн секторын эрхлэгч Б.Энх-Амгалан, орчуулагчаар хуульч Б.Лхагважаргал нар ажилласан.



Энэхүү эрдэм шинжилгээний семинар нь Талуудын хооронд 2021 онд байгуулагдсан хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд хийж буй 5 дахь удаагийн семинар

бөгөөд оролцогч байгууллагын тоо, цар хүрээ тэлж, семинарын үр өгөөж, ач холбогдол улам бүр нэмэгдэж байна. Хамтарч зохион байгуулсан 5 удаагийн

эрдэм шинжилгээний семинарын илтгэлийг эмхэтгэн хэвлүүлж, олны хүртээл болгохоор ажиллаж байна.



ХӨДӨЛМӨРИЙН ГАНЦААРЧИЛСАН МАРГААН БОЛОН ХӨДӨЛМӨРИЙН ГОМДЛЫН ТУХАЙ

Сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороо гомдлыг хамтын гэрээ, салбар, салбар дундын Хөдөлмөрийн тухай хуульд заасан журмаар шийдвэрлэнэ



Хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан болон хөдөлмөрийн гомдол гаргах хугацаа?

Ажилтан ба ажил олгогчийн хооронд хөдөлмөрлөх эрхтүүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлын хүрээнд саналын зөрүү үүсвэл хөдөлмөрийн ганцаарчилсан маргаан болдог.



☎ 1800-1202 🌐 nli.gov.mn ⓘ Хууль зүйн үндэсний хүрээлэн



Хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа?

Сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороо гомдлыг хамтын гэрээ, салбар, салбар дундын Хөдөлмөрийн тухай хуульд заасан журмаар шийдвэрлэнэ.

Гурван талт хороо өргөлдөл хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор маргааныг хянаж, шийдвэр гаргана. Тус хорооны тэмдэглэлийг хүлээн авснаас хойш, эсхүл шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор маргалдагч тал шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

Маргааныг хянан шийдвэрлэснээс хойш ажлын 10 өдрийн дотор талууд шүүхэд нэхэмжлэл гаргаагүй бол уг шийдвэрийг талууд заавал биелүүлэх үүрэгтэй.

☎ 1800-1202 🌐 nli.gov.mn ⓘ Хууль зүйн үндэсний хүрээлэн



Хөдөлмөрийн маргаанд хамаарах хугацаа:

Хөдөлмөрийн эрхийн маргааныг маргалдагч тал эрхээ зөрчигдсэнийг мэдсэн буюу мэдэх ёстой байсан өдрөөс хойш дараах хугацаанд маргааныг урьдчилан шийдвэрлүүлэхээр хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисст, хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссгүй аж ахуйн нэгж, байгууллага болон иргэд хооронд үүссэн маргааныг сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороонд тус тус хандах эрхтэй:

- Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан буюу дуусгавар болгосон, эсхүл өөр ажилд шилжүүлсэн, сэлгэн ажиллуулсан тухай ажил олгогчийн шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл түүнийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор;
- Дээрх нөхцөлөөс бусад хөдөлмөрийн эрхийн маргаантай асуудлыг 90 хоногийн дотор.

☎ 1800-1202 🌐 nli.gov.mn ⓘ Хууль зүйн үндэсний хүрээлэн



Ямар маргааныг шүүхээр хянан шийдвэрлэх вэ?

Дараах маргааныг комисст хандахгүйгээр шүүхээр хянан шийдүүлнэ. Үүнд:

- Сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хорооны тэмдэглэлийг хүлээн авснаас хойш, эсхүл гурван талт хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл
- Албан үүргээ гүйцэтгэж байх үедээ эсвэл онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээгээр ажиллах явцдаа ажил олгогчийн эд хөрөнгөд хохирол учруулсанаас бусад ажил олгогчид учруулсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн нэхэмжлэл;
- Хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээний нөхцөл, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ нь хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчсөн тухай ажилтны гомдол;
- Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс, сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороогоор урьдчилан шийдвэрлэх явцад талууд маргаантай асуудлаар харилцан тохиролцсон бөгөөд үүргээ биелүүлээгүй талаарх гомдол;
- Сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороо хөдөлмөрийн эрхийн маргааныг хянан шийдвэрлэснээс хойш ажлын 10 өдрийн дотор талууд шүүхэд нэхэмжлэл гаргаагүй бол уг шийдвэрийг талууд заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй талаарх гомдол;
- Хууль тогтоомжид заасан бусад маргаан.

Шүүхэд хэрэг үүсгэсэн өдрөөс хойш 60 хоногийн дотор хэргийг шийдвэрлэх ба шаардлагатай бол 30 хоногоор нэг удаа энэ хугацаагаар сунгадаг.

☎ 1800-1202 🌐 nli.gov.mn ⓘ Хууль зүйн үндэсний хүрээлэн

<https://legalinfo.mn/mn> хуудаснаас уншаарай.

**ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГЭЭС 2024 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 107 ДУГААР СУРГУУЛИЙН
СУРАГЧДАД “ТЭГШ ЭРХИЙН ЗАРЧИМ БА ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС АНГИД БАЙХ НЬ”
СЭДЭВТ СУРГАЛТ ОРЛОО.**

Сургалтад Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хувийн эрх зүйн секторын эрдэм шинжилгээний ахлах ажилтан С.Нарантунгалаг хичээл зааж, ахлах ангийн 320 гаруй сурагчид хамрагдлаа.



1800-1202

ЦАГИЙН ХУВААРЬ

08:30-17:30

ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЛИЙН
ЛАВЛАХ ДУГААРТ **08:30-17:30** ЦАГИЙН
ХООРОНД ЭНГИЙН УТАСНЫ ТАРИФААР
ХОЛБОГДОХ БОЛОМЖТОЙ

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН НЭРЭМЖИТ 2024 ОНЫ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ “ШИЛДЭГ БҮТЭЭЛ”, “ШИЛДЭГ ИЛТГЭЛ”, “ШИЛДЭГ ТӨСӨЛ” ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ БҮТЭЭЛ ХҮЛЭЭН АВЧ БАЙНА.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэрэмжит “Шилдэг бүтээл”, “Шилдэг илтгэл”, “Шилдэг төсөл” шалгаруулах уралдаанд хууль зүйн шинжлэх ухаан, аюулгүй байдал, хууль зүй, дотоод хэргийн салбарын эрдэм шинжилгээ, сургалтын байгууллага, судлаачдын баг, судлаач, мэргэжлийн холбоод, хууль зүйн бакалаврын сургалт эрхэлдэг их, дээд сургуулийн оюутан, сонсогчид та бүхнийг оролцохыг урьж байна.

Бүтээлийг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хүлээн авна.



ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН
ЯАМ



ДОТООД ХЭРГИЙН
ИХ СУРГУУЛЬ



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭН

Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэрэмжит
2024 оны эрдэм шинжилгээний

“ШИЛДЭГ БҮТЭЭЛ” “ШИЛДЭГ ИЛТГЭЛ” “ГРАНТ ОЛГОХ ТӨСӨЛ”

шалгаруулах уралдаан зарлагдлаа.



УДИРДАМЖ

Уралдаанд хууль зүйн шинжлэх ухаан, аюулгүй байдал, дотоод хэрэг, онцгой байдлын салбарын эрдэмтэн, судлаачид, судлаачдын баг, мэргэжлийн холбоод, гадаад, дотоодын хууль зүйн их, дээд сургуулийн оюутан, сонсогчид бүтээл, илтгэл, төслөөрөө оролцох боломжтой.

Бүтээл хүлээн авах:
mojha_buteel@legalinstitute.mn
91239123

Илтгэл хүлээн авах:
mojha_iltgel@legalinstitute.mn
89283688

Төсөл хүлээн авах:
mojha_grant@legalinstitute.mn
96138388

Бүтээл, илтгэл, төслийг 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хүлээн авна.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИВЭЭЛ ДОР ЖИЛ БҮР УЛАМЖЛАЛ БОЛОН ЗОХИОГДДОГ ҮНДЭСНИЙ 36 ДАХЬ УДААГИЙН “НОМЫН БАЯР” 2024 ОНЫ 9 САРЫН 13-15-НЫ ӨДРҮҮДЭД ТӨВ ТАЛБАЙД ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БАЙНА. НОМЫН БАЯРТ ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГЭЭС ЭРХЛЭН ГАРГАДАГ НОМ, СУДАЛГААНЫ ЭМХЭТГЭЛҮҮД БОРЛУУЛАГДАЖ БАЙНА

Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилгын хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн гаргадаг ном, сэтгүүл, гарын авлагуудыг иргэдэд тарааж байна



**“НЭР ТОМЬЁО БА ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ХӨГЖИЛ-2024” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫГ ХАМТРАН ЗОХИОН БАЙГУУЛЛАА**

Монгол Улсын Ерөнхийлөгч

Ухаанаагийн Хүрэлсүхийн ивээл

дор зохион байгуулагдах Улсын нэр

томьёоны комиссын 100 жилийн

ойд зориулсан “НЭР ТОМЬЁО БА

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН

ХӨГЖИЛ-2024” олон улсын эрдэм

шинжилгээний хурлын 2024 оны 9

дүгээр сарын 13-ны өдөр Төрийн

ордонд боллоо.

Хурлыг Хууль зүйн үндэсний хүрээлэн,

Монгол Улсын Ерөнхийлөгчийн

Тамгын газар, Хэлний бодлогын

үндэсний зөвлөл, ШУА-ийн Хэл

зохиолын хүрээлэн болон холбогдох

бусад байгууллагууд хамтран зохион

байгууллаа.

олон улсын шинжилгээний хуралд

Монгол, Австри, Швейцарь, Япон,

Солонгос, ОХУ, Колумб, Финланд,

БНХАУ зэрэг 9 улсын 62 илтгэгч 32

илтгэл хэлэлцүүлж байна. Оролцогчид

Монгол дахь нэр томьёо судлалын

түүхэн хөгжил, нэр томьёоны

тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх

ажлыг сайжруулах томьёо онцлов.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30

дугаар байранд үндэсний байгууллагын

30.2 дахь хэсэгт заасны дагуу хууль

зүйн шинжлэх ухааны үндэслэлтэй

онол, дүгнэлт гаргах, хууль зүйн

үндэслэлтэй болгох, нэр томьёотой

холбоотой асуудлаар зөвлөмж гаргах


зөвлөмжийг хууль зүйн хяналтад тусгах

төвийн захирал Х. Эрдэм-Ундрах

“Хууль зүйн том зөвлөлийн үндсэн чиг


үүрэг, нэрьёо судлалын үйл ажиллагаа”

сэдвээр илтгэл хэлэлцүүлж оролцлоо.



“ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН”-ЭЭС 2024 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 20-НЫ ӨДӨР БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХАНГАЙ ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН СУРАГЧДАД “ЦАХИМ ОРЧИН ДАХЬ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТААС АНГИД БАЙХ НЬ” СЭДЭВТ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА. СУРГАЛТАД ТУС СУРГУУЛИЙН АХЛАХ АНГИЙН 120 ГАРУЙ СУРАГЧ ХАМРАГДЛАА.

Сургалтыг Эрдэм шинжилгээний ажилтан Б.Ариунжаргал, Г.Болор-Эрдэнэ нар заав.



nli.gov.mn Хууль зүйн үндэсний хүрээлэн 011-31-5735



nli.gov.mn Хууль зүйн үндэсний хүрээлэн 011-31-5735



nli.gov.mn Хууль зүйн үндэсний хүрээлэн 011-31-5735



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН




08:30-17:30
ЦАГИЙН ХУВААРЬ

ИРГЭН ТА ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ,
МЭДЭЭЛЭЛ АВАХЫГ ХҮСВЭЛ



1800-1202

ДУГААРТ ХОЛБОГДООРОЙ



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГЭЭС 2024 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 20-НЫ ӨДӨР
БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН НИЙТ АЛБАН ХААГЧДАД “ХҮНИЙ ЭРХИЙН
ХАНДЛАГА ТӨЛӨВШҮҮЛЭХ НЬ” СЭДЭВТ СУРГАЛТЫГ ОРЛОО.

Тус сургалтын сургагч багшаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Нийтийн эрх зүйн секторын Эрдэм шинжилгээний ахлах ажилтан
Р.Хатансайхан ажиллалаа.


nli.gov.mn
[Хууль зүйн үндэсний хүрээлэн](#)

☎ 011-31-5735


nli.gov.mn
[Хууль зүйн үндэсний хүрээлэн](#)

☎ 011-31-5735


nli.gov.mn
[Хууль зүйн үндэсний хүрээлэн](#)

☎ 011-31-5735



1800-1202

ЦАГИЙН ХУВААРЬ

08:30-17:30

ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЛИЙН
ЛАВЛАХ ДУГААРТ **08:30-17:30** ЦАГИЙН
ХООРОНД ЭНГИЙН УТАСНЫ ТАРИФААР
ХОЛБОГДОХ БОЛОМЖТОЙ

Нээлттэй засгийн түншлэлийн Улс
орныг дэмжих албаны дарга Алонсо
Сердан болон Ази, Номхон далайн
бүсийн ахлах зохицуулагч Деви Барнас
нар Хууль зүйн үндэсний хүрээлэнд

2024 оны 9 дүгээр сарын 23-ний өдөр
зочиллоо.
Тус уулзалтад ХЗҮХ-ийн Эрдэмтэн
нарийн бичгийн дарга М.Түвшинжаргал
Нээлттэй засгийн түншлэлийн үйл

ажиллагааны үндэсний төлөвлөгөөний
хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний
талаар харилцан мэдээлэл солилцож,
цаашдын хамтын ажиллагааг
өргөжүүлэн хөгжүүлэхээр тохиролцов.



nli.gov.mn

Хууль зүйн үндэсний хүрээлэн

011-31-5735

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН АЛБА ХААГЧИД “ҮНДЭСНИЙ БИЧГЭЭР ЦАХИМД БИЧВЭР БОЛОВСРУУЛАХ” СЭДЭВТ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан хаагчид
“Үндэсний бичгээр цахимд бичвэр боловсруулах” сэдэвт
сургалтад хамрагдлаа

nli.gov.mn

Хууль зүйн үндэсний хүрээлэн

011-31-5735

ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Уг сургалтаар MNS:6395:2022 стандартын дагуу албан хэргийг
хос бичгээр хөтлөх, монгол бичгийн үсгийн фонтыг хэрхэн
суулгах, бичих, цахим бичвэр боловсруулах арга зүй зэрэгт
суралцав.


Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 96 дугаар тогтоолоор
баталсан “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр III”, Монгол
Улсын Засгийн газрын 2022 оны “Монгол хэлний тухай хуулийг
хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 7 дугаар тогтоол,
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн нийт албан хаагчдын
2024 оны дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу 2024 оны 09
дүгээр сарын 19-ний өдөр “Үндэсний бичгээр цахимд бичвэр
боловсруулах” сэдэвт сургалт зохион байгуулж нийт албан хаагч
хамрагдлаа.

Энэхүү сургалтыг Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын
албаны Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Г.Хэрлэнцэцэг,
Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн ажлын албаны Эрдэм
шинжилгээний ажилтан М.Гэрэлсүрэн нар орлоо.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН АЛБАН ХААГЧИД “ГАМШИГ, ГАЛ ТҮЙМРЭЭС
УРДЧИЛАН СЭРГИЙЛЭХ” СЭДЭВТ СУРГАЛТАД ХАМРАГДЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан хаагчид
“Гамшиг, гал түймрээс урьдчилан сэргийлэх”
сэдэвт сургалтад хамрагдлаа

nli.gov.mn Хууль зүйн үндэсний хүрээлэн 011-31-5735



nli.gov.mn Хууль зүйн үндэсний хүрээлэн 011-31-5735

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн нийт албан хаагчдын 2024 оны дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг гамшиг, гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймэр унтраах арга ажиллагаанд сургах, мэдлэгийг нь дээшлүүлэх зорилгоор 2024 оны 09 дүгээр сарын 20-ний өдөр “Гамшиг, гал түймрээс урьдчилан сэргийлэх” сэдэвт сургалт зохион байгуулж нийт албан хаагч хамрагдлаа. ус сургалтыг Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Ангиллын сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, хошууч А.Түвшинбаатар орлоо.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН НИЙТ АЛБАН ХААГЧДЫН 2024 ОНЫ ДОТООД
СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН АЛБАН ХААГЧДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН
БАТАЛГААХАНГАХХӨТӨЛБӨРИЙНХҮРЭЭНДЭРҮҮЛАЖТӨРӨХ,ХӨДӨЛГӨӨНИЙДУТАГДЛААС
УРДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИЛГООР НАРИЙН МЭРГЭЖЛИЙН ЭМЧЭЭС “АЖЛЫН БАЙРНЫ
ЭРҮҮЛ ХЭВШИЛ, НУРУУНЫ ӨВЧЛӨЛ” СЭДВЭЭР СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨГ 2024 ОНЫ 09 ДҮГЭЭР
САРЫН 27-НИЙ ӨДӨР ЗОХИОН БАЙГУУЛАВ.

ус сургалтыг Уламжлалт анагаах ухааны хүний их эмч Н. Баярмагнай орлоо.



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан хаагчид
“Ажлын байрны эрүүл хэвшил” сэдэвт сургалтад
хамрагдлаа

nli.gov.mn Хууль зүйн үндэсний хүрээлэн 011-31-5735



nli.gov.mn Хууль зүйн үндэсний хүрээлэн 011-31-5735




nli.gov.mn Хууль зүйн үндэсний хүрээлэн 011-31-5735

ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ЭМХЭТГЭЛИЙН 2024 ОНЫ 24, 25, 26 ДАХЬ ДУГААРУУД
ХЭВЛЭГДЛЭЭ100 ДАХЬ ДУГААРЫН СЭТГҮҮЛД ХЭВЛЭГДЭХ БҮТЭЭЛИЙГ 11САРЫН 1-ИЙГ ХҮРТЭЛ ХҮЛЭЭН
АВНА.

“ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС” СЭТГҮҮЛД БҮТЭЭЛ ХҮЛЭЭН АВЧ БАЙНА

ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

“Хууль дээдлэх ёс”
сэтгүүлийн 2024 оны IV
улирлын болон англи хэл
дээрх тусгай дугаарт
бүтээл нийтлүүлэхийг
урьж байна.



Хянан магадлалын хураамж:
100,000 төгрөг



Бүтээл хүлээн авах хугацаа:

- 1 IV улирлын дугаарт
нийтлэх бүтээл- XI САРЫН
01 хүртэл
- 2 Англи хэл дээрх тусгай
дугаарт нийтлэх бүтээл-
X сарын 31 хүртэл



Цахим шуудан: lawjournal@legalinstitute.mn



Холбоо барих утас: 99049334

ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ЭМХЭТГЭЛИЙН 2024 ОНЫ 24, 25, 26 ДАХЬ ДУГААРУУД
ХЭВЛЭГДЛЭЭ

Оролцогч улсууд нь өөрсдийн эрх зүйн болон засаг захиргааны тогтолцоондоо хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үндэсний байгууллагуудын үйл ажиллагаа, эрх зүйн байдлын талаарх зарчмуудыг анхааралдаа авна.

<https://mlsp.gov.mn/content/detail/1115>

<https://legalinfo.mn/mn>



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц



НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас
2006 оны 12 дугаар сарын 13-ны өдөр
баталсан Хөгжлийн бэрхшээлтэй
хүмүүсийн эрхийн тухай конвенцид
Монгол Улс
2008 оны 12 сарын 19-ны
өдөр нэгдэн орсон.

Оролцогч улсууд нь өөрсдийн эрх зүйн болон засаг захиргааны тогтолцоондоо хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үндэсний байгууллагуудын үйл ажиллагаа, эрх зүйн байдлын талаарх зарчмуудыг анхааралдаа авна.

Энэхүү конвенцийн зарчмууд нь:

- 1 Сонголт хийх эрх чөлөө болон хүний бие даасан байдлыг оролцуулан хүний нэр төр, нандин чанар, хувийн хараат бус байдлыг хүндэтгэх;
- 2 Алагчилахгүй байх;
- 3 Нийгэмд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох болон хамрагдах;
- 4 Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн онцлог байдлыг хүндэтгэх, тэднийг хүний лавтай байдал, хүн төрөлхтний нэг хэсэг гэж хүлээн авах;
- 5 Тэгш боломж олгох;
- 6 Хүртээмжтэй байх;
- 7 Эрэлтэй, эмэгтэйчүүдийн тэгш эрхтэй байх;
- 8 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хувьсаж өөрчлөгдөх чадамжийг хүндэтгэх болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өөрийн онцлог байдлаа хадгалах эрхийг хүндэтгэн хамгаалах.

Улаанбаатар хотод

үйл ажиллагаа явуулдаг тусгай сургалттай
ЗУРГААН СУРГУУЛЬ ажиллаж явуулж байна

116 дугаар сургууль харааны бэрхшээлтэй	25, 55, 63, 70 дугаар сургуулиуд оюуны бэрхшээлтэй
29 дүгээр сургууль сонсголын бэрхшээлтэй	